

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАГДСАН ИНД-47-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">Агаарын хөлгийн бүртгэл болон тэмдэглэгээ (Шинэчлэгдэж байгаа) / 18 хуудас/ 2015 оны NZ amend.5</p>	<p align="center">АГААРЫН ХӨЛГИЙН БҮРТГЭЛ, ТАНИХ ТЭМДЭГ (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /10 хуудас (үндсэн дүрэм-31 хуудастай байсан)/ 1997оны NZ amend.1</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг-Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>47.1. Зорилго Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) агаарын хөлгийг Монгол Улсад бүртгэх; (2) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт үндэсний харъяаллын тэмдэг болон бүртгэлийн дугаар олгох; (3) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт таних тэмдэг байрлуулах.</p>	<p>47.1. Зорилго (а) Энэ дүрмийн зорилго нь агаарын хөлгийг Монгол Улсад бүртгэх, Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөгт үндэсний болон бүртгэлийн таних тэмдэг олгох, таних тэмдгийг байрлуулахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад оршино.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>47.3. Нэр томъёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</p>		<p>-Нэр томъёоны тайлбар ИНД-1-д орсон</p>
<p>В Бүлэг-Агаарын хөлгийн бүртгэл болон бүртгэлийн гэрчилгээ</p>	<p>Б БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН БҮРТГЭЛ, БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ</p>	
<p>47.51. Агаарын хөлгийн бүртгэл болон гэрчилгээний шаардлага (а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмшиж байгаа этгээд нь, хэрэв агаарын хөлөг нь Монгол Улс руу, Монгол Улсаас, Монгол Улсын нутаг дэвсгэрт, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр нисэх бол тухайн агаарын хөлгийг бүртгүүлж, дараах хүчинтэй бүртгэлийн гэрчилгээ эзэмших үүрэгтэй: (1) Даргын олгосон; эсхүл (2) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч улсын зохих нисэхийн эрх бүхий байгууллагын олгосон; эсхүл (3) Монгол Улсын Засгийн газартай, эсхүл ИНЕГ-тай, бүртгэлийг харилцан хүлээн зөвшөөрөх талаар байгуулсан гэрээний оролцогч тал болох бусад улсын нисэхийн эрх бүхий байгууллагын олгосон. (б) Энэ зүйлийн (а) хэсэг нь дараах зүйлд хамаарахгүй: (1) ИНД-148-ын дагуу гэрчилгээжсэн агаарын хөлөг</p>	<p>47.51. Агаарын хөлгийн бүртгэл, бүртгэлийн гэрчилгээнд тавигдах шаардлага (а) Энэ зүйлийн (б) хэсэгт зааснаас бусад тохиолдолд, Монгол Улс руу, Монгол Улсаас, Монгол Улсын нутаг дэвсгэрт, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр нислэг үйлдэх агаарын хөлөг нь дор дурдсан эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр улсын бүртгэлийн гэрчилгээтэй байна: 1/ Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ-ын гэх)-ын даргаас; эсхүл 2/ Чикагогийн конвенцийн Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагаас; эсхүл 3/ Монгол Улсын Засгийн газартай гэрээ байгуулсан болон Монгол Улсын ИНЕГ-ын даргаас харилцан хүлээн зөвшөөрсөн бусад улсын эрх бүхий байгууллагаас тус тус олгосон. (б) Энэ зүйлийн (а) хэсгийн заалт нь дараах агаарын хөлгүүдэд хамаарахгүй. Үүнд: 1/ ИНД-148 “Агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд анги</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -28 хоногийн шаардлагыг орхигдуулсан -агаарын хөлгийг бүртгүүлэх эзэмшигчийн үүргийг тодорхой болгосон</p>

<p>үйлдвэрлэх байгууллагын шинээр үйлдвэрлэсэн бөгөөд шалгах нислэг хийх зорилгоор ИНД-21-ийн дагуу тусгай нислэгийн зөвшөөрөл олгогдсон агаарын хөлөгт; эсхүл</p> <p>(2) агаарын хөлөг, эсхүл төхөөрөмжөөр ИНД-101, 105, эсхүл 106-гийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээдэд; эсхүл</p> <p>(3) энэ Дүрмийн хэрэгжилтийг үйл ажиллагааны нөхцөлөөр шаардсанаас бусад тохиолдолд, Хууль болон ИНД-102-ын дагуу олгосон хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд, хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд.</p> <p>(с)Хэрэв тухайн агаарын хөлөг нь бусад Улсын бүртгэлтэй бол Монгол Улсад бүртгэхгүй байж болно.</p>	<p>үйлдвэрлэгч байгууллагыг гэрчилгээжүүлэх” дүрмийн дагуу гэрчилгээжсэн үйлдвэрлэгчийн шинээр үйлдвэрлэсэн, шалгах нислэг үйлдэх зорилгоор ИНД-21 “Агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд ангийг гэрчилгээжүүлэх” дүрмийн дагуу тусгай нислэгийн зөвшөөрөл олгогдсон агаарын хөлөг; 2/ иргэний нисэхийн багц дүрмийн ИНД-101 “Хүнгүй нисдэг төхөөрөмж болон автожир-үйл ажиллагаа”, ИНД-105 “Шүхрийн үйл ажиллагаа”, ИНД-106 ”Дельтаплан- үйл ажиллагаа”-д заасан нисэх төхөөрөмж буюу агаарын хөлгүүд.</p> <p>(в) Гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгийг Монгол Улсад бүртгэхгүй.</p>	<p>-ИНД-102-т хамаарахгүй байх тухай (3) заалт нэмэгдсэн</p>
<p>47.53. Бүртгүүлэх болон гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах</p> <p>(а) Агаарын хөлгийг бүртгүүлэх болон Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг дараах этгээд, эсхүл түүний нэрийн өмнөөс гаргах үүрэгтэй:</p> <p>(1) тухайн агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмшиж байгаа этгээд; эсхүл</p> <p>(2) хүсэлтэд заасан өдрөөс эхлэн, тухайн агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмших эрхтэй болох этгээд.</p> <p>(б) Хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг шаардсан САА 24047/01 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгч, загвар болон серийн дугаар;</p> <p>(2) энэ зүйлийн (а)(1), эсхүл (2)-т заасан этгээдийн нэр болон Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх хаяг;</p> <p>(3) энэ зүйлийн (а)(1), эсхүл (2)-т заасан, агаарын хөлөг болон этгээдтэй холбоотой, тухайн маягтад тусгагдсан Даргын шаардаж болох бусад нэмэлт мэдээлэл.</p> <p>(с) Дарга хүсэлт гаргагч, эсхүл түүний нэрийн өмнөөс хүсэлт гаргасан этгээдээс тухайн нөхцөл байдалд тохируулан дараах баримтыг бүгдийг, эсхүл заримыг гаргаж өгөхийг шаардаж болно:</p> <p>(1) тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгч, загвар болон</p>	<p>47.53. Агаарын хөлгийг бүртгүүлэх өргөдөл</p> <p>(а) Агаарын хөлгийг бүртгүүлэхээр өргөдөл гаргагч (цаашид Өргөдөл гаргагч гэх) нь тухайн агаарын хөлгийн хууль ёсны өмчлөгч, эзэмшигч эсхүл тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч байна.</p> <p>(б) Өргөдөл гаргагч нь дараах мэдээллийг ИНЕГ-047/01 маягтын дагуу ИНЕГ-ын даргад ирүүлэх ба өргөдөлд төлбөрийн баримтыг хавсаргасан байна:</p> <p>1/ агаарын хөлгийн маяг, үйлдвэрлэлийн дугаар, үйлдвэрлэгчийн талаарх мэдээлэл;</p> <p>2/ энэ зүйлийн (а) хэсэгт заасан Монгол Улсад үйл ажиллагаа явуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг;</p> <p>3/ агаарын хөлгийн хууль ёсны өмчлөгч, эсхүл эзэмшигчтэй холбоотой мэдээлэл.</p> <p>(в) ИНЕГ-ын дарга нь шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагчаас дор дурдсан баримтуудыг шаардаж болно:</p> <p>1/ агаарын хөлгийн маяг, үйлдвэрлэгч, үйлдвэрлэлийн дугаарыг нотлох баримт;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.3-аар 180 хоногийн шаардлага нэмэгдсэн</p>

серийн дугаарыг нотлох баримт;
 (2) энэ зүйлийн (а)(1), эсхүл (2)-т заасан этгээдийг таньж тогтоох нотлох баримт;
 (3) энэ зүйлийн (а)(1), эсхүл (2)-т заасан этгээд тухайн агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмшиж байгаа, эсхүл хүсэлтэд заасан өдрөөс эхлэн эзэмших эрхтэй болох тухай албан ёсны мэдүүлэг.

(d) Агаарын хөлгийг энэ дүрмийн дагуу бүртгүүлэх хүсэлт гаргагч нь Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ авах агаарын хөлгийн хувьд, ИНД-21-ийн дагуу тусгай категорийн-үзүүлбэрийн НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл тусгай категорийн-хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл гэрчилгээ олгогдох бол, 47.55(d)-д шаардсан үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээллийг Даргад хүргүүлэх үүрэгтэй.

2/ энэ зүйлийн (а) хэсэгт заасан иргэн, хуулийн этгээдийг тодорхойлох нотлох баримт;
 3/ энэ зүйлийн (а) хэсэгт заасан иргэн, хуулийн этгээдээс тухайн агаарын хөлгийн хууль ёсны өмчлөгч, эсхүл эзэмшигч мөн болохыг тодорхойлсон хууль ёсны мэдүүлэг.

-Amend.3-аар (d)заалт нэмэлтээр орсон

47.55. Бүртгэл болон гэрчилгээ олгох
 (a) Энэ зүйлийн (с)-г харгалзан, хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь агаарын хөлгийг бүртгүүлж, Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмших эрхтэй:

(1) Хуулийн дагуу, тухайн агаарын хөлөг нь өөр улсад бүртгэгдээгүй байх;
 (2) хүсэлт гаргагч нь 47.53(b)-ийн холбогдох шаардлагыг хангасан байх;
 (3) 47.53(c)-ийн дагуу шаардаж болох нотлох баримт болон албан ёсны мэдүүлэг нь хүлээн зөвшөөрөхүйц байх;

(4) тухайн агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмших этгээд нь тохирох зөв хүн байх;
 (5) хэрэв тухайн агаарын хөлөг нь ИНД-21-ийн дагуу тусгай категорийн-үзүүлбэрийн НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл тусгай категорийн-хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл гэрчилгээ олгогдох бол, энэ зүйлийн (d)-д шаардсан мэдээлэл нь хүлээн зөвшөөрөхүйц байх;
 (6) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

47.55. Агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох
 (a) ИНЕГ-ын дарга нь дор дурдсан шаардлагыг хангасан өргөдөл гаргагчийн агаарын хөлгийг Монгол Улсын бүртгэлд бүртгэж, Агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ (цаашид Бүртгэлийн гэрчилгээ гэх) олгоно:
 1/ тухайн агаарын хөлөг нь өөр улсад бүртгэлгүй байх;

2/ энэ дүрмийн 47.53-ын (б)-д заасан шаардлагыг хангасан байх;
 3/ ИНЕГ-ын даргаас шаардлагатай гэж үзсэн, энэ дүрмийн 47.53-ын (в) хэсэгт заасан нотлох баримт болон хууль ёсны мэдүүлэг нь хүлээн зөвшөөрөхүйц байх;

4/ агаарын хөлгийн хууль ёсны өмчлөгч, эсхүл эзэмшигч нь эрх зүйн чадвартай байх;

5/ бүртгэлийн гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагааны эрх ашигт харшлахгүй байх.

(б) ИНЕГ-аас шаардлага хангасан гэж үзвэл энэ зүйлийн (а)-д заасны дагуу Бүртгэлийн гэрчилгээ олгож, Монгол Улсын

28 хоногийн шаардлага Amend.3-аар нэмэгдсэн

(b) Хэрэв **Дарга** шаардлага хангагдсан гэж үзвэл, энэ зүйлийн (a)-д заасны дагуу бүртгэлийн гэрчилгээ олгож, ИНЕГ нь Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системд дараах мэдээллийг оруулах үүрэгтэй:

- (1) тухайн бүртгэсэн огноо;
- (2) тухайн хүсэлтэд заасан агаарын хөлгийн тодорхойлолт;
- (3) тухайн агаарын хөлгийг **180 хоног**, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмших этгээдийн нэр болон үйл ажиллагаа эрхлэх хаяг;
- (4) **Дарга** 47.103-ын дагуу, тухайн агаарын хөлөгт олгосон бүртгэлийн дугаар;
- (5) 47.104-ийн дагуу зөвшөөрсөн, танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний тодорхойлолт, хэрэв хамааралтай бол.

(c) ИНД-21-ийн дагуу тусгай категорийн-үзүүлбэрийн НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл тусгай категорийн-хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл гэрчилгээ олгогдох агаарын хөлгийн хувьд, энэ зүйлийн (a)-ийн дагуу олгосон бүртгэлийн гэрчилгээнд энэ зүйлийн (d)-д заасан үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэл дагалдсан байх ёстой.

(d) Үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэл нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

- (1) тухайн агаарын хөлгийн хийц, загвар болон бүртгэлийн дугаар;
- (2) дараах этгээдийн нэр:
 - (i) тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчийг төлөөлж байгаа этгээд;
 - (ii) тухайн агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагааг удирдаж байгаа болон багийн гишүүдийн сургалт хариуцсан этгээд;
 - (iii) тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээг удирдах үүрэг хариуцлага хүлээсэн этгээд;
- (3) минимум түлшний нөөцтэй хэвийн аяллын хурдаар нисэх максимум нислэгийн цагийг багтаасан, VFR-ийн дагуу тухайн агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд шаардлагатай минимум нөөц түлшний дэлгэрэнгүй мэдээлэл;
- (4) тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээний үндсэн гүйцэтгэгчийн нэр;
- (5) ИНД-91.605(b)(2)-оор шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн таних тодорхойлолт;

иргэний агаарын хөлгийн бүртгэлд дараах мэдээллийг оруулна:

- 1/ агаарын хөлгийг бүртгэсэн он, сар, өдөр;
- 2/ өргөдөлд дурдсан агаарын хөлгийн талаарх тодорхойлолт болон хамаарах мэдээлэл;
- 3/ агаарын хөлгийн хууль ёсны өмчлөгч, эзэмшигчийн нэр, хаяг;

4/ энэ дүрмийн 47.103-т заасны дагуу **ИНЕГ**-ын даргаас агаарын хөлөгт олгосон бүртгэлийн таних тэмдэг;

5/ хамааралтай бол энэ дүрмийн 47.104-д заасны дагуу зөвшөөрөгдсөн, агаарын хөлгийн будган зураглал болон тэмдэглэгээний тодорхойлолт.

(в) **ИНЕГ-ын дарга шаардлагатай гэж үзвэл агаарын хөлгийг тодорхой хугацаагаар бүртгэж болно.**

28 хоногийн шаардлага Amend.3-аар нэмэгдсэн

-Amend.3-аар (c), (d) хэсэг шинээр нэмэгдсэн

- (6) тухайн агаарын хөлгөөр, ажиллагаагүй төхөөрөмжтэйгээр үйл ажиллагаа гүйцэтгэх журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) тухайн агаарын хөлгөөр явгалалт үйлдэх этгээдэд тавих хязгаарлалт, эсхүл үр чадварын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (8) тухайн агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэхтэй холбоотой хязгаарлалтын дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэв хамааралтай бол;
- (9) дараах мэдээллийг агуулсан, тухайн агаарын хөлөгт суурилүүлсан харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон системийн талаарх мэдээлэл:
 - (i) суурилүүлсан төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (ii) нислэгийн үед ашиглах журам;
 - (iii) тухайн агаарын хөлөгт техник үйлчилгээ хийдэг, эсхүл бусад хэлбэрээр түүнд нэвтэрдэг этгээдийн сургалтын журам болон суурилүүлсан харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон системийн аюулгүй байдлын дадлага туршлага;
 - (iv) харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон системд зориулсан нөөц тэслэгч зэрэг хадгалагдаж байгаа төхөөрөмжийн хяналтыг багтаасан газарт мөрдөх аюулгүй байдлын арга хэмжээ;
 - (v) ИНД-66-гийн дагуу олгогдсон МАС эзэмшдэг бөгөөд суурилүүлсан харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон системд техник үйлчилгээ хийхээр бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчийн зөвшөөрсөн этгээдийн нэр;
 - (vi) суурилүүлсан харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон систем дээр сургалт зохион байгуулах ажлыг хариуцсан этгээдийн нэр;
 - (vii) суурилүүлсан харвах суудал, гарцын тэсрэх төхөөрөмж, эсхүл жэттисон систем байгаа болохыг, мөн шаардлагатай аюулгүй байдлын урьдчилсан анхааруулгын талаар орон нутгийн онцгой байдлын үйлчилгээний нэгжид мэдээлэх үүрэг хариуцлага хүлээсэн этгээдийн нэр.

47.57. Агаарын хөлгийн Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч солигдох

(а) Агаарын хөлгийн Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийг хууль ёсоор өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн бол эрх дуусгавар болсон өдрөөс эхлэн агаарын хөлгийн Бүртгэлийн

-28 хоногийн шаардлага нэмэгдсэн

<p>гэрчилгээ эзэмшигч тухайн агаарын хөлгийг хууль ёсоор эзэмшихээ зогсоосон өдрөөс эхлэн тухайн гэрчилгээ хүчингүй болно.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу гэрчилгээ нь хүчингүй болсон гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) хүчингүй болсон өдрөөс хойш 14 хоногийн дотор:</p> <p>(i) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээний ар талын хэвлэмэл маягтыг; эсхүл</p> <p>(ii) САА 24047/03 маягтыг бүрэн гүйцэд бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт <u>Даргад</u> хүргүүлэх; эсхүл</p> <p>(2) хамааралтай бол 47.67(b)-гийн дагуу Даргад мэдэгдэх.</p>	<p>гэрчилгээг хүчингүй болсонд тооцно.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-ийн дагуу агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон этгээд нь Бүртгэлийн гэрчилгээ хүчингүй болсон өдрөөс хойш 14 хоногийн дотор ИНЕГ-047/03 маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт <u>ИНЕГ</u>-т ирүүлнэ.</p>	
<p><u>47.59. Гэрчилгээний хугацаа дууссаны дараах агаарын хөлгийн үйл ажиллагаа</u></p> <p>(a) <u>Энэ дүрмийн 47.51(a)-г үл харгалзан, Монгол Улс руу, Монгол Улсаас, Монгол Улсын нутаг дэвсгэрт, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийг хууль ёсоор эзэмших эрхтэй этгээдийг 47.57(a)-ийн дагуу тухайн гэрчилгээний хугацаа дууссанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй, Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээтэй байхыг шаардахгүй.</u></p> <p>(b) <u>Энэ дүрмийн 47.57(a)-ийн дагуу Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээний хугацаа дууссанаас 28 хоногийн дараа, Дарга агаарын хөлөгт бүртгэлийн гэрчилгээ олгох хүртэл тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.</u></p>	<p>47.59. Нөөц</p>	<p>-Нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан</p>
<p>47.61. Гэрчилгээний мэдээллийн хүчинтэй байдал</p> <p>(a) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийн хүчинтэй байдалд нөлөөлөх өөрчлөлтийг <u>Даргад</u> нэн даруй мэдэгдэх үүрэгтэй:</p> <p>(1) тухайн гэрчилгээнд агуулагдсан мэдээлэл; эсхүл</p> <p>(2) 47.55(c)-д шаардсан үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэлд агуулагдсан мэдээлэл.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу мэдэгдэл хүлээн авсны дараа, <u>Дарга</u> Хуулийн дагуу тухайн бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулж, эсхүл хүчингүй болгож, түүний оронд шинэ гэрчилгээ олгох бол, ИНЕГ нь Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системийн холбогдох мэдээллийг шинэчлэх үүрэгтэй.</p> <p>(c) <u>Хэрэв энэ зүйлийн (a)(2)-ын дагуу мэдэгдсэн өөрчлөлт нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц бол Дарга 47.55(c)-д шаардсан</u></p>	<p>47.61. Бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах</p> <p>(a) Бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан, Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчтэй холбоотой аливаа мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ тухайгаа ажлын 5 өдөрт багтаан <u>ИНЕГ-ын</u> даргад мэдэгдэнэ.</p> <p>(б) Хэрэв энэ зүйлийн (a)-ын дагуу мэдэгдэл ирүүлсэн тохиолдолд, <u>ИНЕГ</u> нь агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээнд шаардлагатай өөрчлөлтийг оруулах эсхүл хүчингүй болгож гэрчилгээг дахин шинэчлэн олгоно.</p>	<p>-Amend.3-аар (c), (d) хэсэг нэмэгдсэн</p>

<p>үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэлд агуулагдсан мэдээлэлд нэмэлт оруулж болно.</p> <p>(d) Хэрэв Дарга тухайн өөрчлөлт нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзвэл, 47.55(с)-д шаардсан үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэлд агуулагдсан мэдээлэлд өөрчлөлт оруулж болно.</p>		
<p>47.63. Гэрчилгээг солих</p> <p>(a) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд, гэрчилгээ солиулах хүсэлт гаргаж болно, хэрэв тухайн гэрчилгээ нь:</p> <p>(1) гээгдсэн, алдагдсан, эсхүл устсан бол; эсхүл</p> <p>(2) мэдээлэл нь уншигдах боломжгүйгээр гэмтсэн бол.</p> <p>(b) Гэрчилгээ солиулах хүсэлт гаргагч нь САА 24047/01 маягтыг бөглөж, дараах баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) зохих төлбөрийн баримт;</p> <p>(2) хамааралтай бол тухайн гэмтэлтэй гэрчилгээ.</p>	<p>47.63. Бүртгэлийн гэрчилгээг нөхөн олгох</p> <p>(a) Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд гэрчилгээг нөхөн олгох тухай хүсэлт гаргана:</p> <p>1/ Бүртгэлийн гэрчилгээг алдаж үрэгдүүлсэн; эсхүл</p> <p>2/ Бүртгэлийн гэрчилгээг гэмтээсэн, эсхүл гэрчилгээний бичилт бүдгэрч арилсан.</p> <p>(б) Бүртгэлийн гэрчилгээ нөхөн олгуулахаар хүсэлт гаргагч нь ИНЕГ-047/01 маягтыг бөглөж, төлбөрийн баримт, гэмтсэн болон алдаж үрэгдүүлсэн болохыг нотлох баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>47.65. Гэрчилгээний хугацаа</p> <p>(a) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ нь:</p> <p>(1) 47.57(a)-ийн дагуу хүчингүй болсон; эсхүл</p> <p>(2) Дарга түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй байна.</p> <p>(b) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлсэн бол, эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.</p> <p>(c) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон бол, эзэмшигч нь гэрчилгээг Даргад нэн даруй хураалгах үүрэгтэй.</p> <p>(d) ИНД-21-ийн дагуу олгогдсон тусгай категорин-үзүүлбэрийн НТЧ-ын гэрчилгээ, эсхүл тусгай категорин-хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээ бүхий агаарын хөлгийн хувьд, 47.55(с)-д шаардсан үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэл нь зөвхөн, энэ зүйлийн (a)-ийн дагуу тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээний хүчинтэй хугацаанд хүчинтэй байна.</p>	<p>47.65. Бүртгэлийн гэрчилгээний хугацаа</p> <p>(a) Бүртгэлийн гэрчилгээ нь дор дурдсанаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр байна:</p> <p>1/ энэ дүрмийн 47.57 -ийн дагуу гэрчилгээ хүчингүй болсон; эсхүл</p> <p>2/ ИНЕГ-ын дарга гэрчилгээг түдгэлзүүлэх буюу хүчингүй болгох хүртэл.</p> <p>(б) Бүртгэлийн гэрчилгээг аюулгүй ажиллагааны шаардлагын үүднээс түдгэлзүүлсэн нөхцөлд гэрчилгээ эзэмшигч холбогдох зөвшөөрөл болон цаашид авах арга хэмжээнд зориулан ажлын 5 өдөрт багтаан гэрчилгээг ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p> <p>(в) Бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон, эсхүл гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийг хууль ёсоор өмчлөх, эзэмших эрх дуусгавар болсон нөхцөлд ажлын 5 өдөрт багтаан гэрчилгээг ИНЕГ-ын даргад хураалгана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.3-аар (d) хэсэг нэмэгдсэн</p>
<p>47.67. Агаарын хөлөг эвдрэх, устаж алга болох,</p>	<p>47.67. Агаарын хөлгийн тухай мэдүүлэг</p>	<p>-Орчуулга найруулга</p>

<p>хулгайлагдах, ашиглалтаас хасагдах, эсхүл гадаадад бүртгүүлэх</p> <p>(a) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд, энэ зүйлийн (b)-гийн дагуу Даргад мэдэгдэх үүрэгтэй:</p> <p>(1) тухайн агаарын хөлөг дараах нөхцөл байдалд орсныг мэдсэнээс хойш 14 хоногийн дотор:</p> <p>(i) эвдэрсэн, устаж алга болсон, эсхүл хулгайлагдсан; эсхүл</p> <p>(ii) ашиглалтаас бүрмөсөн хасагдсан; эсхүл</p> <p>(2) тухайн агаарын хөлгийг өөр улсын агаарын хөлгийн бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргасны дараа яаралтай мэдэгдэх.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу гаргах мэдэгдэл нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <p>(1) бичгээр үйлдсэн байх;</p> <p>(2) тухайн гэрчилгээ эзэмшигч гарын үсэг зурсан байх;</p> <p>(3) тухайн болсон нөхцөл байдлыг тодорхойлсон байх;</p> <p>(4) тухайн бүртгэлийн гэрчилгээг хавсаргасан байх.</p>	<p>(a) Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд агаарын хөлгийн тухай мэдүүлгийг ИНЕГ-ын даргад ирүүлнэ:</p> <p>1/ агаарын хөлгийг удаан хугацаагаар ашиглалтаас хассан, удаан хугацаагаар ашиглалтаас чөлөөлөх болсон, агаарын хөлөг осолдож сүйрсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор; эсхүл</p> <p>2/ агаарын хөлгийг өөр улсад бүртгүүлэх бол.</p> <p>(б) Энэ зүйлийн (a) хэсэгт заасны дагуу гаргах мэдүүлэг нь доорх шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ бичгээр үйлдсэн байх;</p> <p>2/ нөхцөл шалтгааны талаар тодорхой тайлбарласан;</p> <p>3/ бүртгэлийн гэрчилгээг хавсаргасан;</p> <p>4/ гэрчилгээ эзэмшигч гарын үсэг зурж баталгаажуулсан.</p>	<p>зассан</p>
<p>47.69. Бүртгэлийг цуцлах</p> <p>(a) Агаарын хөлөг нь дараах нөхцөл үүсэх хүртэл бүртгэлтэй хэвээр байна:</p> <p>(1) бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн агаарын хөлгийн гэрчилгээг хүчингүй болгох хүсэлтийг гаргасан ба Дарга гэрчилгээг хүчингүй болгосон; эсхүл</p> <p>(2) Дарга, дараах нотлох баримтыг хангалттай гэж үзэн, тухайн бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон:</p> <p>(i) тухайн агаарын хөлөг эвдэрсэн, устаж алга болсон, эсхүл хулгайлагдсаныг; эсхүл</p> <p>(ii) тухайн агаарын хөлгийг ашиглалтаас бүрмөсөн хассаныг; эсхүл</p> <p>(iii) тухайн агаарын хөлгийг 180 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар хууль ёсоор эзэмшиж байгаа этгээд нь тухайн агаарын хөлгийг өөр улсад бүртгүүлэх хүсэлт гаргасныг; эсхүл</p> <p>(iv) тухайн агаарын хөлөг нь Монгол Улсаас өөр Улсад бүртгэгдсэнийг, эсхүл</p> <p>(3) Дарга, Хуулийн дагуу тухайн бүртгэлийн гэрчилгээг өөр байдлаар хүчингүй болгосон, эсхүл</p> <p>(4) Дарга:</p> <p>(i) 47.57(a)-д заасны дагуу бүртгэлийн гэрчилгээний</p>	<p>47.69. Агаарын хөлгийн бүртгэлийг хүчингүй болгох</p> <p>(a) Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийн бүртгэлийг хүчингүй болгуулахаар ИНЕГ-ын даргад хүсэлт гаргах хүртэл тухайн агаарын хөлгийн бүртгэл хүчинтэй хэвээр хадгалагдана.</p> <p>(б) ИНЕГ-ын дарга дараах тохиолдолд агаарын хөлгийн Бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгож улсын бүртгэлээс хасна:</p> <p>1/ агаарын хөлөг осолдож сүйрсэн; эсхүл</p> <p>2/ агаарын хөлөг ашиглалтаас гарсан; эсхүл</p> <p>3/ агаарын хөлгийг өөр улсад бүртгүүлэхээр болсон.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p> <p>-Орхигдуулсан</p>

<p><u>хугацаа дууссаныг тогтоосон;</u> (ii) <u>тухайн гэрчилгээний хугацаа дууссан өдрөөс хойш 14 хоногийн дотор 47.53-ын дагуу хүсэлт хүлээж аваагүй.</u></p> <p>(b) <u>ИНЕГ нь дараах тохиолдолд Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системд тухайн агаарын хөлгийг оруулахгүй байх үүрэгтэй, хэрэв Дарга:</u> (1) <u>энэ зүйлийн (a)(1), (2), эсхүл (3)-т заасны дагуу тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээнд эргэлзэж байгаа бол; эсхүл</u> (2) <u>энэ зүйлийн (a)(4)-т заасан асуудал байгааг тогтоосон бол.</u></p> <p>(c) <u>Энэ зүйлийн (a)(1)-ийг үл харгалзан, хэрэв ИНЕГ нь агаарын хөлгийг бүртгэлээс бүрмөсөн хасуулах болон экспортын зөвшөөрөл авахаар хүргүүлсэн хүсэлтийг бүртгэсэн бол, бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох хүсэлтийг Даргад гаргахгүй байж болно.</u></p>		<p>-Amend.4-өөр (c) хэсэг нэмэгдсэн</p>
<p>47.71. Агаарын хөлгийн үндэсний харъяалал Энэ дүрмийн 47.55-ын (a)-ийн дагуу Даргын бүртгэсэн агаарын хөлөг нь Монгол Улсын үндэсний харъяалалтай байна.</p>	<p>47.71. Агаарын хөлгийн харъяалал (a) Агаарын хөлгийг энэ дүрмийн 47.55-ын (a) хэсэгт заасны дагуу бүртгүүлсэн бол уг агаарын хөлөг нь Монгол Улсын харъяалалтай байна.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p>С Бүлэг-Агаарын хөлгийн тэмдэглэгээ</p>	<p>В БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН ТАНИХ ТЭМДЭГ</p>	
<p>47.101. Агаарын хөлгийн тэмдэглэгээнд тавих шаардлага (a) Энэ зүйлийн (b), (c), (d) болон (e)-д зааснаас бусад тохиолдолд, Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээнд хамаарах агаарын хөлөгт дараах тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан болохыг бататгах үүрэгтэй: (1) 47.103-ын дагуу олгосон бүртгэлийн дугаар болон 47.109 - 47.117-гийн шаардлагын дагуу үндэсний харъяаллын тэмдэг; (2) <u>47.119-ийн шаардлагын дагуу таних пайз;</u> (b) Монгол Улсын бүртгэлтэй дараах маягийн агаарын хөлгийг Монгол Улсад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа үед үндэсний харъяаллын тэмдэг байрлуулахыг шаардахгүй: (1) <u>МСТOW нь 2270</u>кг, эсхүл түүнээс бага жинтэй нисэх онгоц; (2) <u>роторт-хөлөг;</u> (3) <u>глайдер</u> болон <u>моторт-глайдер;</u></p>	<p>47.101. Таних тэмдэгт тавигдах шаардлага (a) Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (б), (в) болон (г) хэсгүүдэд зааснаас бусад тохиолдолд үндэсний болон бүртгэлийн таних тэмдэг, таних пайзыг дор дурдсаны дагуу агаарын хөлөгт байрлуулна: 1/ бүртгэлийн таних тэмдгийг энэ дүрмийн 47.103-т заасны дагуу; (б) Монгол Улсын нутаг дэвсгэрт нислэг үйлдэж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй дараах агаарын хөлөгт үндэсний таних тэмдгийг байрлуулахгүй байж болно: 1/ <u>5700</u> кг буюу түүнээс доош хөөрөлтийн жинтэй онгоц; 2/ <u>нисдэг тэрэг;</u> 3/ <u>хөдөлгүүртэй, хөдөлгүүргүй планер;</u> 4/ хүнтэй хийн бөмбөлөг; 5/ ИНД-21 “Агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-5700-г 2270 болгож бууруулсан</p> <p>-Rotorcraft – “нисдэг</p>

<p>(4) хүнтэй бөмбөлөг; (5) ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон тусгай категорийн НТЧ-ын гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисэх онгоц.</p> <p>(с) Монгол Улс дотор, Цагдаагийн байгууллагын Даргын зөвшөөрлөөр цагдаагийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт 47.102-ын дагуу олгосон цагдаагийн таних тэмдэг байрлуулсан бол, <u>47.103</u>-ын дагуу олгосон үндэсний харъяаллын тэмдэг, эсхүл бүртгэлийн дугаар байрлуулахыг шаардахгүй.</p> <p>(d) <u>Хэрэв тухайн агаарын хөлөгт 47.104-ийн дагуу зөвшөөрсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг байрлуулсан бол, Монгол Улс дотор үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт 47.103-ын дагуу олгосон үндэсний харъяаллын тэмдэг, эсхүл бүртгэлийн дугаар байрлуулахыг шаардахгүй.</u></p> <p>(е) Энэ зүйлийн (е)-гийн дагуу зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг байрлуулсан агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь 47.109-д заасны дагуу будган зураглал болон тэмдэглэгээг тухайн агаарын хөлөгт үргэлжлүүлэн харуулж байгааг бататгах үүрэгтэй.</p>	<p>ангийг гэрчилгээжүүлэх” дүрмийн Е бүлгийг үндэслэн олгосон тусгай ангиллын Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээний дагуу ашиглагдаж буй онгоц.</p> <p>(в) Монгол Улсын нутаг дэвсгэрт нислэг үйлдэж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн будган зураглал ба тэмдэглэгээ нь <u>47.104</u>-т заасны дагуу зөвшөөрөгдсөн бол 47.103-т заасны дагуу үндэсний болон бүртгэлийн таних тэмдгийг байрлуулахгүй байж болно.</p> <p>(г) Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийн зөвшөөрөгдсөн будган зураглал болон тэмдэглэгээг энэ дүрмийн 47.109-д заасны дагуу агаарын хөлөгт байрлуулж, бататгасан байна.</p>	<p>тэрэг” гэснийг “роторт хөлөг” болгож өөрчилсөн</p> <p><i>-Gliders and powered gliders-</i> “хөдөлгүүртэй, хөдөлгүүргүй планер” гэснийг <u>“глайдер болон моторт-глайдер”</u> гэж өөрчилсөн</p>
<p>47.102. Цагдаагийн агаарын хөлгийн таних тэмдэг <u>Монгол Улсын бүртгэлтэй цагдаагийн агаарын хөлөгт байрлуулах таних тэмдэг нь дараах тэмдэглэгээнээс бүрдсэн байх ёстой:</u></p> <p>(1) <u>“POLICE”-ийн ард Цагдаагийн байгууллагын Даргын олгосон дугаар;</u> (2) <u>Цагдаагийн байгууллагын Дарга олгоход зориулан Даргын нөөцөлсөн бүртгэлийн дугаар.</u></p>		<p>-Amend.2-оор нэмэгдсэн</p>
<p>47.103. Үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар</p> <p>(а) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн үндэсний харъяаллын тэмдэг нь “JU” гэсэн том үсэг байх ёстой.</p> <p>(b) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн бүртгэлийн дугаар нь дараах шаардлага хангасан байх ёстой: (1) тухайн агаарын хөлөгт <u>Дарга</u> оноосон байх; (2) дөрвөн тооноос бүрдэх ба үндэсний харъяаллын тэмдгийн ард байрлан, хөндлөн зураасаар тусгаарлагдсан байх.</p>	<p>47.103. Үндэсний болон бүртгэлийн таних тэмдэг</p> <p>(а) Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн үндэсний таних тэмдэг нь “JU” гэсэн хоёр үсгээс бүрдэх ба үсгүүдийг томоор бичнэ.</p> <p>(б) Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн бүртгэлийн таних тэмдэг нь <u>4 (дөрөв)</u> тооноос бүрдэх ба үндэсний таних тэмдгээс зураасаар тусгаарлагдсан байна.</p> <p>(в) Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн бүртгэлийн таних тэмдгийг <u>ИНЕГ</u>-ын дарга олгоно.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

47.104. Танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний зөвшөөрөл

- (a) ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу тусгай категорийн НТЧ-ын гэрчилгээ олгогдсон агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь, 47.103-ын дагуу олгосон үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар байрлуулахын оронд, тухайн агаарын хөлөгт танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулах зөвшөөрлийг Даргаас хүсэж болно.
- (b) ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон стандарт, эсхүл хязгаарлалттай категорийн НТЧ-ын гэрчилгээ олгогдсон агаарын хөлөг, эсхүл хэт хөнгөн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь 47.103-ын дагуу олгосон үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар байрлуулахын оронд, тухайн агаарын хөлөгт түүхэн зорилгоор өөр танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулах зөвшөөрлийг Даргаас хүсэж болно.
- (c) Танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг шаардсан САА 24047/04 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:
- (1) тухайн агаарын хөлөгт Даргаас олгосон үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар;
 - (2) санал болгож байгаа агаарын хөлгийн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний бичгээр үйлдсэн тодорхойлолт;
 - (3) санал болгож байгаа агаарын хөлгийн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг өнгөт зураг, фото зураг, гар зураг, эсхүл төстэй хэлбэрээр үнэн зөв харуулсан гурван-талт зураг;
 - (4) Даргын шаардаж болох, эсхүл бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчтэй холбоотой маягтад тусгагдсан бусад нэмэлт мэдээлэл.
- (d) Хэрэв будган зураглал болон тэмдэглэгээ нь тухайн агаарын хөлгийг ижил, эсхүл төстэй маяг болон загварын бусад агаарын хөлгөөс ялгахад хангалттай гэж үзвэл, Дарга энэ зүйлийн (a)-ийн дагуу танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулах хүсэлтийг зөвшөөрч болно.
- (e) Хэрэв тухайн будган зураглал болон тэмдэглэгээ нь түүхэн, эсхүл бусад тусгай зорилготой тохирч байгаа бөгөөд тухайн агаарын хөлгийг ижил, эсхүл төстэй маяг болон загварын

-Amend.3-аар
нэмэгдсэн

“Микролай-хэт хөнгөн”

<p><u>бусад агаарын хөлгөөс ялгахад хангалттай гэж үзвэл, Дарга энэ зүйлийн (b)-гийн дагуу танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулах хүсэлтийг зөвшөөрч болно.</u></p> <p>(f) <u>Энэ зүйлийн (d), эсхүл (e)-гийн дагуу зураг, эсхүл гар зургийг үндэслэн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээтэй агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь, зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг байрлуулсан агаарын хөлгийн гурван-талт фото зургийг Даргад хүргүүлэх үүрэгтэй.</u></p>		
<p>47.105. Танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээний бүртгэл</p> <p>(a) 47.104-ийн дагуу зөвшөөрсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг 47.55-ын (b)-гийн дагуу <u>Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системд</u> оруулсан байх үүрэгтэй.</p>	<p>47.105. Агаарын хөлгийн будган зураглал болон тэмдэглэгээний бүртгэл</p> <p>(a) Энэ дүрмийн 47.104-д заасны дагуу зөвшөөрөгдсөн, агаарын хөлгийн будган зураглал болон тэмдэглэгээг энэ дүрмийн 47.55-ын (б) хэсэгт заасны дагуу Монгол Улсын иргэний агаарын хөлгийн бүртгэлд оруулна.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p>47.106. Танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээг өөрчлөх</p> <p>(a) Тухайн будган зураглал, эсхүл тэмдэглэгээг өөрчлөхөөр төлөвлөж байгаа, 47.104-ийн дагуу зөвшөөрсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулсан агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь 47.104-ийн дагуу шинэ будган зураглал болон тэмдэглэгээний зөвшөөрөл авах хүсэлтийг <u>Даргад</u> гаргах үүрэгтэй.</p> <p>(b) Энэ дүрмийн 47.104-ийн дагуу зөвшөөрсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ байрлуулсан агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн будган зураглал, эсхүл тэмдэглэгээг хэрэглэхээ зогсоохоор төлөвлөж байгаа бол дараах үүрэгтэй:</p> <p>(1) <u>Даргад</u> бичгээр зохих журмаар мэдэгдэх;</p> <p>(2) 47.101-ийн дагуу тухайн агаарын хөлөгт таних тэмдэг байрлуулах.</p>	<p>47.106. Агаарын хөлгийн будган зураглал болон тэмдэглэгээг өөрчлөх</p> <p>(a) Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийн зөвшөөрөгдсөн будган зураглал болон тэмдэглэгээг өөрчлөх тохиолдолд энэ дүрмийн 47.104-д заасны дагуу <u>ИНЕГ</u>-ын даргад хүсэлт гаргана.</p> <p>(б) Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн 47.104-д заасны дагуу зөвшөөрөгдсөн будган зураглал болон тэмдэглэгээг цаашид ашиглахгүй тохиолдолд энэ тухайгаа <u>ИНЕГ</u>-ын даргад бичгээр мэдэгдэж энэ дүрмийн 47.101-т шаардсан үндэсний болон бүртгэлийн таних тэмдгийг агаарын хөлөгтөө байрлуулна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>47.107. Бүртгэлийн дугаар нөөцлөх</p> <p>(a) Агаарын хөлгийг Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системд бүртгүүлэхээр төлөвлөж байгаа этгээд нь зохих төлбөрийг төлж, бүртгэлийн дугаар нөөцлүүлэх хүсэлтийг <u>Даргад</u> гаргаж болно.</p> <p>(b) <u>Дарга</u>, энэ зүйлийн (a)-ийн дагуу гаргасан хүсэлтийг хүлээн аваад дараах тохиолдолд бүртгэлийн дугаарыг 24 сараас дээшгүй хугацаагаар нөөцөлж болно, хэрэв:</p>	<p>47.107. Бүртгэлийн таних тэмдгийг нөөцлөх</p> <p>(a) Аливаа этгээд нь өөрийн өмчлөл, эсхүл эзэмшилд байгаа агаарын хөлгийг Монгол Улсын бүртгэлд бүртгүүлэхийн тулд бүртгэлийн таних тэмдгийг нөөцлүүлэх хүсэлтээ <u>ИНЕГ</u>-ын даргад гаргаж болно.</p> <p>(б) Бүртгэлийн таних тэмдгийг нөөцлөх тухай хүсэлтийг дор дурьдсанаас бусад тохиолдолд 24 сараас дээшгүй хугацаагаар хадгална:</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(1) тухайн дугаарыг олгоогүй, эсхүл нөөцлөөгүй бол; (2) тухайн дугаарыг ашиглах нь тохиромжгүй гэж Дарга үзээгүй бол. (с) Энэ зүйлийн (b)-гийн дагуу нөөцөлсөн бүртгэлийн дугаарыг нөөцөлсөн тухайн хугацаанд, нөөцлөхийг хүссэн этгээд хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд, тухайн бүртгэлийн дугаарыг агаарын хөлөгт олгохгүй.</p>	<p>1/ тухайн бүртгэлийн таних тэмдгийг өөр агаарын хөлөгт олгоогүй буюу нөөцлөөгүй бол; 2/ тухайн бүртгэлийн таних тэмдгийг ашиглахад тохирохгүй гэж ИНЕГ-ын дарга үзээгүй бол. (в) Энэ зүйлийн (б) хэсэгт заасны дагуу нөөцөлсөн бүртгэлийн таних тэмдгийг, хүсэлт гаргасан этгээдийн өөрийнх нь хүсэлтээр бусдад шилжүүлж болно.</p>	
<p>47.108. Бүртгэлийн дугаар өөрчлөх (a) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд заасан, тухайн агаарын хөлөгт олгосон бүртгэлийн дугаарыг шинэ бүртгэлийн дугаараар солих хүсэлтийг Даргад гаргаж болно. (b) Хүсэлт гаргагч нь бүртгэлийн дугаар өөрчлөх хүсэлтийг бичгээр гарган, дараах мэдээллийг хавсарган Даргад хүргүүлэх үүрэгтэй: (1) тухайн бүртгэлийн гэрчилгээ; (2) тухайн хүсэж байгаа бүртгэлийн дугаар; (3) зохих төлбөрийн баримт. (с) Дарга, энэ зүйлийн (b)-д заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг хүлээн аваад, тухайн агаарын хөлөгт олгосон бүртгэлийн дугаарыг хураан авч, шинэ бүртгэлийн дугаар олгож болно. (d) Энэ зүйлийн (с)-гийн дагуу шинэ бүртгэлийн дугаар олгосон тохиолдолд, ИНЕГ нь тухайн агаарын хөлөгт олгосон шинэ бүртгэлийн дугаарын мэдээллийг Монгол Улсын Агаарын Хөлгийн Бүртгэлийн системд оруулах үүрэгтэй.</p>	<p>47.108. Бүртгэлийн таних тэмдгийг өөрчлөх (a) Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд заасан бүртгэлийн таних тэмдгийг өөрчлөх хүсэлтээ ИНЕГ-ын даргад гаргаж болно. (б) Хүсэлт гаргагч нь бүртгэлийн таних тэмдэг өөрчлөх өргөдөлд төлбөрийн баримт болон дараах зүйлсийг хавсарган ИНЕГ-ын даргад ирүүлнэ: 1/ Бүртгэлийн гэрчилгээ; 2/ шинээр авах бүртгэлийн таних тэмдгийн санал. (в) ИНЕГ-ын дарга нь энэ зүйлийн (б) хэсэгт заасан өргөдлийг хүлээн авсан тохиолдолд, тухайн агаарын хөлөгт олгосон бүртгэлийн таних тэмдгийг хүчингүй болгож, шинээр бүртгэлийн таних тэмдэг олгох асуудлыг шийдвэрлэнэ. (г) ИНЕГ-ын даргаас энэ зүйлийн (в) хэсэгт заасны дагуу бүртгэлийн шинэ таних тэмдгийг агаарын хөлөгт олгосон тохиолдолд Монгол Улсын агаарын хөлгийн бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>47.109. Таних тэмдэг байрлуулах (a) 47.101-ийн дагуу байрлуулахыг шаардсан үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаар, эсхүл 47.104-ийн дагуу зөвшөөрсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ нь дараах шаардлагыг хангасан байх ёстой: (1) тухайн агаарын хөлөгт будсан, эсхүл түүнтэй төстэй түвшинд тогтвортой байхыг бататгасан аргаар бэхэлсэн байх; (2) тухайн агаарын хөлгийн хийц, эсхүл хэлбэрт тохируулан, хамгийн тохиромжтой хэсэгт ил харагдахуйц байрлуулсан байх; (3) байнга цэвэр, тод харагдахуйц байх. (b) Үндэсний харъяаллын үсэг, бүртгэлийн дугаарын тоо болон холбоос зураас нь ижил өнгөтэй байх ба тэдгээрийг будсан, эсхүл бусад хэлбэрээр бэхэлсэн дэвсгэрээс тод ялгарч</p>	<p>47.109. Таних тэмдгийн харагдац (a) Энэ дүрмийн 47.101-т шаардсан үндэсний болон бүртгэлийн таних тэмдгийг, эсвэл 47.104-д заасан зөвшөөрөгдсөн, агаарын хөлгийн будган зураглал болон тэмдэглэгээг дараах шаардлагын дагуу агаарын хөлөгт байрлуулна: 1/ гадны аливаа нөлөөнд хялбар гэмтэж арилахгүй будгаар будаж, эсхүл тусгай зориулалтын материалаар хийж агаарын хөлөгт бэхлэнэ; 2/ агаарын хөлгийн хийц загварын онцлогоос хамааран хамгийн тохиромжтой хэсэгт ил харагдахуйц газар байрлуулах; ба 3/ таних тэмдэг нь тод харагдахуйц байна; 4/ үсэг, тоо болон холбоос зураас бүр нь ижил өнгөтэй байх бөгөөд суурь гадаргуугаас тод ялгарсан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>харагдахуйц байх ёстой.</p> <p>(с) <u>Цагдаагийн байгууллагын Даргын зөвшөөрсөн цагдаагийн үйл ажиллагааны бүх хугацаанд, цагдаагийн таних тэмдгийг энэ Бүлгийн бусад шаардлагын дагуу хийгдсэн болохыг бататгах хэлбэрээр агаарын хөлөгт байрлуулах ёстой.</u></p>		<p>-Amend.3-аар (с)-ээр нэмэгдсэн</p>
<p>47.111. Агаараас хөнгөн агаарын хөлөгт таних тэмдэгт байрлуулах</p> <p>(а) Дирижабльд, 47.101(а)-ийн дагуу шаардсан таних тэмдгийг дараах байдлаар байрлуулах ёстой:</p> <p>(1) дирижаблийн их биеийн максимум хөндлөн огтлолын хэсгийн ойролцоо, уртын дагуу босоо гадаргууд тэгш хэмтэй; эсхүл</p> <p>(2) дараах <u>тэнцвэржүүлэгч</u> дээр:</p> <p>(i) хэвтээ <u>тэнцвэржүүлэгчийн</u> баруун хагасын дээд гадаргууд болон зүүн хагасын доод гадаргууд, тоо болон үсгийн орой нь дайрах булан тийш чиглэсэн;</p> <p>(ii) босоо <u>тэнцвэржүүлэгчийн</u> хоёр талын доод хагаст, тоо болон үсгийг босоогоор.</p> <p>(b) Бөмбөрцгөн бөмбөлгийн таних тэмдгийг 47.101(а)-д шаардсаны дагуу, тухайн бөмбөлгийн тойргийн максимум хэвтээ тэнхлэгийн хэсэгт, диаметрийн эсрэг хоёр хэсэгт байрлуулах ёстой.</p> <p>(с) Бөмбөрцгөн бус бөмбөлгийн таних тэмдгийг 47.101(а)-д шаардсаны дагуу, тухайн бөмбөлгийн максимум хөндлөн огтлолын шугамын ойролцоо хоёр талд, сагсыг дүүжилсэн татлага олсны бэхэлгээний дээр, эсхүл бөмбөлгийн доод бүслүүрийн дээр байрлуулах ёстой.</p>	<p>47.111. Агаараас хөнгөн агаарын хөлөгт таних тэмдгийг байрлуулах</p> <p>(а) Дирижаблийн их биенд таних тэмдгийг байрлуулахдаа энэ дүрмийн 47.101-ийн (а)-д шаардсаны дагуу их биений хамгийн урт хэсэгт, эсхүл гадаргуугийн хоёр талд болон гадаргуугийн дээд хэсгийн тэгш хэмийн шугамд уртааш нь байрлуулна.</p> <p>(б) Дирижаблийн стабилизаторын гадаргуу дээр таних тэмдгийг дараах байдлаар байрлуулна:</p> <p>1/ хэвтээ <u>стабилизатор</u> дээр таних тэмдгийг, баруун талын дээд гадаргууд болон зүүн талын доод гадаргууд, тоо ба үсгийн орой урагш чиглэсэн байдлаар;</p> <p>2/ босоо <u>стабилизатор</u> дээр таних тэмдгийг, стабилизаторын хоёр талын доод хэсгийн хагаст, тоо болон үсгийн орой дээш чиглэсэн байдлаар тус тус байрлуулна.</p> <p>(в) Бөмбөрцөг хэлбэрт хийн бөмбөлөгийн таних тэмдгийг энэ дүрмийн 47.101-ийн (а)-д шаардсаны дагуу бөмбөрцөгийн тойргийн хамгийн урт хэвтээ тэнхлэгийн хэсэгт болон диаметрийн голч шугамын дагуу эсрэг хоёр талд байрлуулна.</p> <p>(г) Бөмбөрцөг бус хэлбэрт хийн бөмбөлөгийн таних тэмдгийг энэ дүрмийн 47.101-ийн (а)-д шаардсаны дагуу сагсны татлага олсыг бөмбөлөгт бэхлэх хэсгийн дээд талд, эсвэл бөмбөлөгийн доод бүслүүр хэсгийн дээр байрлуулах ба бөмбөлөгийн хамгийн урт хөндлөн огтлолын шугамын ойролцоо тал бүрд нь байрлуулсан байна.</p>	<p>Орчуулга, найруулга зассан</p>
<p>47.113. Агаараас хүнд агаарын хөлөгт таних тэмдэгт байрлуулах</p> <p>(а) Энэ зүйлийн (с) болон (d)-д зааснаас бусад тохиолдолд, нисэх онгоц, глайдер болон моторт-глайдерт 47.101 (а)-д шаардсан таних тэмдгийг дараах байдлаар байрлуулсан байх ёстой:</p> <p>(1) далавчны бүтцийн нэг доод гадаргууд Хэрэв таних тэмдгийг далавчны захын хэсэгт байрлуулах шаардлагатай бол, түүнийг зүүн далавчны доод гадаргууд байрлуулах ёстой. Таних тэмдгийн толгой нь тухайн далавчны дайрах булан руу чиглэсэн байх ба далавчны урд болон хойд ирмэгийн дунд, аль болох</p>	<p>47.113. Агаараас хүнд агаарын хөлөгт таних тэмдгийг байрлуулах</p> <p>(а) Энэ зүйлийн (в) болон (г) хэсгүүдэд зааснаас бусад, хөдөлгүүртэй, хөдөлгүүргүй планер болон онгоцны таних тэмдгийг энэ дүрмийн 47.101-ийн (а)-д шаардсаны дагуу дараах байдлаар байрлуулна:</p> <p>1/ далавчинд байрлуулахдаа далавчны доод гадаргууг дагуулан байрлуулна.</p> <p>Хэрэв таних тэмдгийг далавчны доод гадаргууд бүхэлд нь байрлуулах боломжгүй бол зүүн хагаст нь байрлуулна. Таних тэмдгийг далавчны урд, хойд хэсгийн хооронд ижил хэмжээнд, үсэг болон тоон тэмдэглэгээний орой нь</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>тэнцүү зайтай байхаар байрласан байх ёстой;</p> <p>(2) далавч болон сүүлний гадаргуугийн хооронд, их биеийн хоёр талд хэвтээгээр, эсхүл сүүлний босоо гадаргуугийн дээд хагаст хэвтээгээр. Ганц босоо сүүлний гадаргуу дээрх таних тэмдэг нь 2 талд байх ёстой. Олон босоо сүүлтэй гадаргуу дээрх таних тэмдэг нь захын гадна гадаргуунууд дээр байрласан байх ёстой.</p> <p>(b) Энэ зүйлийн (d)-д зааснаас бусад тохиолдолд, роторт-хөлөгт 47.101(a)(1)-ийн дагуу шаардсан таних тэмдгийг, хэвийн үйл ажиллагааны үед халхлагдахааргүй, ил харагдах хэсэгт дараах байдлаар байрлуулах ёстой:</p> <p>(1) их биеийн, эсхүл бүхээгийн гадна доод гадаргууд;</p> <p>(2) <u>роторт-хөлгийн</u> хоёр талд тэгш хэмтэй.</p> <p>(c) Зөвхөн Монгол Улс дотор үйл ажиллагаа гүйцэтгэдэг нисэх онгоц, <u>глайдер</u> болон моторт-глайдерт, далавчны бүтцийн доод гадаргууд таних тэмдэг байрлуулахыг шаардахгүй.</p> <p>(d) Хэрэв нисэх онгоц, глайдер, моторт-глайдер, эсхүл роторт-хөлөг нь:</p> <p>(1) энэ дүрмийн холбогдох заалтад дурдсан эд ангигүй бол; эсхүл</p> <p>(2) энэ дүрмийн дагуу тэмдэглэх шаардлагатай гадаргуу нь 47.117-д заасан хэмжээтэй таних тэмдгийг байрлуулахад хангалттай том биш бол,</p> <p><u>Дарга</u> дараах тохиолдолд тухайн агаарын хөлгийн өөр аль нэг хэсэгт таних тэмдэг байрлуулахыг зөвшөөрч болно, хэрэв:</p> <p>(i) таних тэмдгийг хэвийн үйл ажиллагааны үед халхлагдахааргүй ил харагдах хэсэгт байрлуулах бол;</p> <p>(ii) таних тэмдэг нь хялбар танигдахаар бол</p>	<p>далавчны урд хэсэг рүү чиглэсэн байдлаар (давхар далавчтай агаарын хөлгийн хувьд "далавч" гэснийг доод далавч гэсэн утгаар ойлгоно);</p> <p>2/ их биенд байрлуулахдаа, далавч болон сүүлний хэсгийн хооронд их биений хоёр талд, эсвэл сүүлний босоо хэсгийн дээд хагаст байрлуулна. Хэрэв нэг босоо сүүлтэй бол сүүлний 2 талд, олон босоо сүүлтэй бол захын босоо сүүлний гадна талуудад.</p> <p>(б) Энэ зүйлийн (в) хэсэгт зааснаас бусад тохиолдолд болон нисдэг тэрэгний таних тэмдгийг энэ дүрмийн 47.101-ийн (а) хэсгийн 1/-д шаардсаны дагуу, ил харагдахуйц газар дараах байдлаар байрлуулна:</p> <p>1/ их биений, эсвэл нисэх багийн бүхээгийн гадна доод гадаргууд;</p> <p>2/ <u>нисдэг тэрэгний</u> гадна хоёр талд тэгш хэмтэй.</p> <p>(в) Монгол Улсын нутаг дэвсгэрт нислэг үйлдэж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй бага оврын онгоц болон хөдөлгүүртэй, хөдөлгүүргүй <u>планерын</u> дал авчны доод гадаргууд таних тэмдэг байрлуулахгүй байж болно.</p> <p>(г) Агаарын хөлгийн тогтоосон хэсгүүдэд энэ дүрмийн 47.117-т заасан хэмжээгээр таних тэмдгийг байрлуулах боломжгүй бол <u>ИНЕГ-ын</u> даргаас зөвшөөрсөн хэсэгт байрлуулна.</p>	
<p>47.115. Таних тэмдгийн тодорхойлолт</p> <p>(a) <u>Үндэсний харьяалал</u> болон бүртгэлийн дугаар нь хээ угалзгүй, латин том үсэг болон араб тооноос бүрдсэн байх ёстой.</p> <p>(b) Үсэг, тоо бүрийн өргөн болон холбоос зураасны урт нь үсгийн өндрийн гуравны хоёртой тэнцүү байх ёстой.</p> <p>(c) Үсэг болон тоо бүр нь үсэг болон тооны өмнө, эсхүл хойно үсгийн өндрийн дөрөвний нэгээс багагүй зайтай байх ба зураас болон тоо нь энэ зорилгоор үсэгтэйгээ адилхан</p>	<p>47.115. Таних тэмдгийн тодорхойлолт</p> <p>(a) Агаарын хөлгийн үндэсний болон бүртгэлийн таних тэмдгүүд нь ямар нэг чимэглэл, хээ угалзгүй, латин том үсэг болон араб тооноос бүрдэнэ.</p> <p>(б) Үсэг, тоо бүрийн өргөн болон холбоос зураасны урт нь үсэг буюу тооны өндрийн гуравны хоёртой тэнцүү байна.</p> <p>(в) Үсэг, тоо буюу холбоос зураас бүрийн хоорондын зай нь үсэг, тооны өргөний дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээнээс багагүй зайгаар тусгаарлагдсан байна.</p>	<p>Орчуулга найруулга зассан</p>

<p>тусгаарлагдсан байх ёстой.</p> <p>(d) Үсэг, тоо болон холбоосыг бүрдүүлж байгаа зураас нь тухайн үсгийн өндрийн зургааны нэгтэй тэнцүү өргөнтэй үргэлжилсэн шугамаар бичигдсэн байх ёстой.</p>	<p>(г) Үсэг, тоо болон холбоос зураас нь таних тэмдгийн өндрийн зургааны нэгтэй тэнцэх өргөн бүхий үргэлжилсэн шугамаар бичигдсэн байна.</p>	
<p>47.117. Таних тэмдгийн хэмжээ</p> <p>(a) Үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар нь ижил өндөртэй үсэг болон тооноос бүрдэх ба тэдгээрийг байрлуулсан гадаргуугийн ирмэгээс дотогш 50 мм-ээс доошгүй нөөц зайг үлдээн байрлуулах ёстой.</p> <p>(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд агаарын хөлгийн таних тэмдгийн өндөр нь <u>250</u> мм-ээс доошгүй байна.</p> <p>(c) <u>Дарга</u>, агаараас хүнд агаарын хөлөгт <u>250</u> мм-ийн өндөртэй таних тэмдгийг байрлуулахад гадаргуу нь хангалттай том биш бол <u>150</u> - <u>250</u> мм-ийн өндөртэй таних тэмдэг байрлуулахыг зөвшөөрч болно.</p>	<p>47.117. Таних тэмдгийн хэмжээ</p> <p>(a) Үндэсний болон бүртгэлийн таних тэмдгүүд нь ижил өндөртэй бичигдэх ба байрлуулах гадаргууны захаас 50 мм-ээс доошгүй зайд байна.</p> <p>(б) Энэ зүйлийн (в) хэсэгт зааснаас бусад тохиолдолд агаарын хөлгийн таних тэмдгийн өндөр нь <u>500</u> мм-ээс доошгүй байна.</p> <p>(в) Агаараас хүнд агаарын хөлөгт 500 мм-ийн өндөртэй таних тэмдгийг байрлуулах боломжгүй бол, <u>150</u> мм-ээс доошгүй өндөртэй таних тэмдэг байрлуулахыг <u>ИНЕГ</u>-ын дарга зөвшөөрч болно.</p> <p>(г) Таних тэмдгийн өндөр нь далавчинд <u>500</u> мм-ээс, их бие болон босоо сүүлний хэсэгт <u>300</u> мм-ээс доошгүй байна.</p>	<p>-Хэмжээ өөрчлөгдсөн</p>
<p>47.119. Таних пайз</p> <p>(a) 47.101(a)-ийн дагуу байрлуулахыг шаардсан таних пайзанд үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаарыг сийлж дүрслэх, цохиж шигтгэх, эсхүл хэвд цутгаж суулгасан байх ёстой.</p> <p>(b) Тухайн таних пайз нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <p>(1) физик шинж чанараараа галд тэсвэртэй металл, эсхүл галд тэсвэртэй бусад материалаар хийсэн байх;</p> <p>(2) тухайн агаарын хөлөг рүү орох гол хаалганы ойролцоо, ил харагдах байрлалд бэхэлсэн байх.</p>	<p>47.119. Таних пайз</p> <p>(a) Энэ дүрмийн 47.101-ийн (a)-д шаардсан таних пайзанд үндэсний болон бүртгэлийн таних тэмдгийг сийлж дүрслэх, цохиж шигтгэх, эсхүл хэвэнд цутгаж суулгасан байна.</p> <p>(б) Таних пайз нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ физик шинж чанараараа галд тэсвэртэй металл буюу материалаар хийгдсэн байна;</p> <p>2/ агаарын хөлөг рүү орох гол хаалганы ойролцоо, ил харагдахуйц газарт бэхлэгдсэн байх ба 90x50 мм-ээс доошгүй хэмжээтэй байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>47.121. Таних тэмдгийг далдлах</p> <p>Аливаа этгээд нь энэ Дүрмийн дагуу агаарын хөлөгт байрлуулахыг шаардсан үндэсний харъяалал, эсхүл бүртгэлийн дугаар зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал болон тэмдэглэгээ, эсхүл цагдаагийн таних тэмдгийг өөрчилсөн, эсхүл халхалсан аливаа таних тэмдэг, эсхүл билэгдлийг Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт байрлуулахгүй байх үүрэгтэй.</p>	<p>47.121. Хориглох зүйл</p> <p>(a) Энэ дүрмийн дагуу агаарын хөлөгт байрлуулсан үндэсний ба бүртгэлийн таних тэмдэг, будган зураглал болон бэлэгдлийг зөвшөөрөлгүй өөрчлөх буюу тэдгээртэй адил төстэй тэмдэг, тэмдэглэгээг Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөгт байрлуулахыг хориглоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>